




“МӨНХИЙН БАЯН ГАЛ” ХХК
Munkhiin Bayan Gal Co., Ltd.

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
НУТАГТ БАЙРЛАХ “МӨНХИЙН БАЯН ГАЛ”
ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Төсөл хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“МӨНХИЙН БАЯН ГАЛ” ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/ВАН МО/

Хянасан:
БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/ П. Шинэцэцэг /

Хэрэгжилтийг гаргасан :
Мөнхийн баян гал ХХК-ны
БО,ХАБЭА-н хэлтсийн дарга

/ Жан Гуан Ли/

Боловсруулсан:
БО,ХАБЭА мэргэжилтэн

/ Д.Даваарэгзэн /

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
Хүснэгт 1. Компаний мэдээлэл	3
Хүснэгт 2. Үйлдвэрийн газрын барилга байгууламжийн эзлэх талбайн гол үзүүлэлтүүд	4
Хүснэгт 3. Үйлдвэрийн ажиллах хүчний үзүүлэлт	5
Хүснэгт 4. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүд	5
1.2 Үйлдвэрийн байршил:	6
1.3 Үйлдвэрлэлийн хүчин чадал:.....	6
1.4 Байгаль орчны баримтлах зарчим:	6
1.5 Үйлдвэрлэлийн технологи:	7
1.6 Түүхий эд	9
Хүснэгт 5. Координат цэг	9
2. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
Хүснэгт 6. Болзошгүй нөлөөллийн схем.....	11
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ ...	13
Хүснэгт 7. Агаарын чанар	13
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	13
Хүснэгт 8. Усны чанар	16
3.2 Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	16
Хүснэгт 9. Ургамлын чанар.....	21
Хүснэгт 10. Улирдлага зохион байгуулалт	22
3.4 Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	22
4. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26
Хүснэгт 11. Ногоон байгууламж	26
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	32
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33
А. Палентологийн судалгаа.....	33
Б. Археологийн судалгаа.....	33
8. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	34
Хүснэгт 12. Химийн бодис	34
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	38
Хүснэгт.13 Хог хаягдал.....	38
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	41
Хүснэгт. 14. ОХШХ ус.....	41
Хүснэгт. 15. ОХШХ Хөрс	42
Хүснэгт. 16. ОХШХ Агаар.....	43
11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	44
Хүснэгт. 17. Зардлын мөнгөн дүн.....	44
11. ДҮГНЭЛТ	45
12. ХАВСРАЛТУУД.....	46

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Үйлдвэрийн байршлын тойм зураг	6
Зураг 2. Үйлдвэрийн технологийн бүдүүвч.....	7
Зураг 3. Технологийн ерөнхий схем	8
Зураг 4. Төлөвлөлтийн тойм зураг	10
Зураг 5. Тоосжилттой орчны хувийн хамгаалах хэрэгсэл	13
Зураг 6. Уутан шүүлтүүр солиж буй байдал.....	14
Зураг 7. Агаарын шинжилгээ хийж буй байдал	15
Зураг 8. Цементийн үйлдвэр орчим тодорхойлсо нхүхэрлэг хий буюу SO_2, NO_2 -ын агууламж	16
Зураг 9. Цэвэрлэх байгууламж засаж буй байдал.....	17
Зураг 10. Усны, хөрсний шинжлээний зураг.....	18
Зураг 11. 130м цооногийн ажлыг бүрэн дуусгав.....	20
Зураг 12. Ажлын байранд үзлэгт хамрагдаж буй байдал.	23
Зураг 13. Галын сараануудыг шинэчилсэн байдал.....	23
Зураг 14. Сургалт зохион байгуулж байгаа байдал.	24
Зураг 15. Сургалт зохион байгуулж байгаа байдал.	25
Зураг 16. Нийт талбайн ногоон байгууламжийн төлөвлөлт.....	27
Зураг 17. Хаврын тарилтын нүх ухааж буй байдал.....	28
Зураг 18. Мод тарилтын дараа болон, тарилтын	29
Зураг 19. Хаагдсан зам, бэлчээрийг гаргаж буй байдал	30
Зураг 20. Өвс, тэжээлийн тусламж хүргэж буй.....	31
Зураг 21. Хадлан хадаж буй байдал	31
Зураг 22. Өдөрлөгт оролцон Мод тарилт хийж буй байдал	32
Зураг 23. Лабораторын хэсэгт сургалт орж буй байдал.....	35
Зураг 24. Үзүүлэх сургалт хийж буй байдал.....	36
Зураг 25. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгч буй байдал.....	37
Зураг 26. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгсөн акт.....	37
Зураг 27. Хог хаягдлыг ачиж, цэвэрлэж байна.....	39
Зураг 28. Нийтийн цэвэрлэгээ хийж буй байдал	39
Зураг 29. Түр хогийн цэгт хөрсний тэгшилгээ хийж буй байдал	40
Зураг 30. Ариутгал халдваргүйтэл хийж байгаа нь	40
Зураг 31. Эко нойл хийлгэсэн байдал	42
Зураг 32. Тээврийн замын усалгаа арчилгаа	43

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Компаний мэдээлэл

ТАЙЛАНГИЙН МЭДЭЭЛЭЛ		
1	<i>Аж ахуй нэгжийн нэр</i>	“Мөнхийн баян гал” ХХК
2	<i>Улсын бүртгэлийн дугаар</i>	9019024058
3	<i>Регистрийн дугаар</i>	5118115
4	<i>Төслийн нэр</i>	Цемент боловсруулах үйлдвэр
5	<i>Газар ашиглах гэрчилгээний дугаар</i>	№ 0000124341
6	<i>Газар ашиглах шийдвэрийн дугаар</i>	Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2022 оны 10 дүгээр сарын 10-ний өдрийн А/1126 тоот
7	<i>Газрын хэмжээ</i>	108 га
8	<i>Газар ашиглах зориулалт</i>	Үйлдвэрлэл
9	<i>Үйлдвэрлэх түүхий эд</i>	Портланд цемент
10	<i>Жилд үйлдвэрлэх хүчин чадал</i>	1 сая тонн
11	<i>Газрын байршил</i>	Төв аймаг Сэргэлэн сум 1 дүгээр баг
12	<i>Үйл ажиллагаа эхэлсэн он</i>	2015 ОН
13	<i>Одоогийн байдал</i>	2024 оны байдлаар Үйлдвэрийн үйл ажиллагаа улирлын хугацаандаа хэвийн ажилласан.
14	<i>Түүхий эд</i>	Шохойн чулуу, шар шороо, төмрийн баяжмал, байгалийн шохой, гөлтгөнө, цеолит, нүүрсний үнс
15	<i>БОННУ-ний тайлан батлагдсан огноо</i>	2022 он
16	<i>БОННУ-ний тайлангийн дугаар</i>	2022/ОА97
17	<i>Ажиллах горим</i>	3 дүгээр сараас 11-р сар хүртэл
18	<i>2024 оны цемент үйлдвэрлэлийн тн хэмжээ</i>	435.898тн цемент үйлдвэрлэв.
19	<i>2024 оны чулуунцар үйлдвэрлэлийн тн хэмжээ</i>	339.085тн чулуунцар /клинкер/ үйлдвэрлэв.



Хүснэгт 2. Үйлдвэрийн газрын барилга байгууламжийн эзлэх талбайн гол үзүүлэлтүүд

Стандартын нэр	Хэмж. нэгж	Тоо хэмжээ
Үйлдвэрийн эзлэх талбай	м ²	326 830
Барилга байгууламжийн эзлэх талбай	м ²	34 200
Түүхий эд хураах талбай	м ²	59 000
Бэлэн бүтээгдэхүүн хураах талбай	м ²	21 000
Үйлдвэр дотоод авто замын нийт урт	м ²	6 500
Автозамын эзлэх талбай	м ²	28 960
Ногоон байгууламж	м ²	32 000
Хөдөлгөөн хийх хатуу хучилттай талбай	м ²	10 328

---ooOOOOOoo---

Хүснэгт 3. Үйлдвэрийн ажиллах хүчний үзүүлэлт


№	Ажлын байр	Нийт ажиллагсдын тоо
А. Үйлдвэрийн хэлтэс		175
1	Контор	5
2	Төвийн хяналтын өрөө	16
3	Түүхий эд бэлтгэх болон хаягдал хий арилгах	42
4	Шатаалт	35
5	Бэлэн бүтээгдэхүүн хадгалах болон тээвэрлэх	13
6	Цемент хийх болон тээвэрлэх	64
Б. Бусад ажил		25
1	Цахилгаан хангах	18
2	Ус гадагшуулах болон уурын зуух, эргэлтийн насос станц шалгагч, сантехникч	7
Нийт		200

Цементийн үйлдвэрийн нийт ажиллагсдын тоо 230 хүн, 2024 оны хувьд одоогийн байдлаар Нийт 100 монгол ажилчид 50 гаруй Хятад инженер техникийн ажилчид, туслан гүйцэтгэгч байгууллагын 70 орчим ажилчид энэ оны үйлдвэрлэлийг гүйцэтгэлээ.

Хүснэгт 4. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Машин, тоног төхөөрөмжийн нэр	Марк, төрөл	Тоо	Хүчин чадал
1	Шохойн чулуу бутлагч	TKLPC 20.22E	1	60тн/цаг
2	Шохойн чулуу нунтаглагч	MLS3626	1	190 тн/цаг
3	Шатаах систем, нам даралтын 5-р зэргийн халаалтын төхөөрөмж, NDF задлах зуух	NDF	1	Голч 4 м, урт 60 м
4	Хөргөлтийн аппарат			
5	Түлшний нүүрс нунтаглагч	HRM 1400	1	18-22 тн/цаг
6	Цемент нунтаглагч	HFCG 150-100	2	110-120 тн/цаг
7	Цемент савлах машин /8 хошуутай/		4	90-100 тн/цаг
8	Хий шахагч станц /4 компрессор/			40 м³/мин, 0,8 мПа

1.2 Үйлдвэрийн байршил: Мөнхийн баян гал цементийн үйлдвэр нь Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урагш 34 км, Сэргэлэн сумаас зүүн тийш 22 км, Налайх дүүргээс урагш 23 км-т Сэргэлэн сумын 1-р багийн нутагт, Төмөр замын 7-р зөрлөгөөс урагш /хуучин орос цэргийн ангийн хойно/салаа төмөр замын далан дагуу цахилгаан дэд станц хүртлэх нутагт нийт 108 га талбайг хамарч оршино.



Зураг 1. Үйлдвэрийн байршлын тойм зураг

Ангилал: “Мөнхийн баян гал” ХХК Боловсруулах үйлдвэр


1.3 Үйлдвэрлэлийн хүчин чадал: Монгол оронд бүтээн байгуулалтын ажил өрнөж, барилгын салбарын үндсэн түүхий эдийн нэг болох цементийн эрэлт, хэрэгцээ жилээс жилд өсөн нэмэгдэж буй энэ үед бид хэрэгцээт цементийнхээ дөнгөж 40 гаруй хувийг дотооддоо үйлдвэрлэж байна. Иймд “Мөнхийн баян гал” ХХК –ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах хоногт 2500 тонн, жилд 1 000 000 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд үүний 200 000 тонн нь P.C 32.5 маркийн холимог цемент, үлдсэн 800 000 тонн нь P.O 42.5 маркийн ердийн цахиурын исэлтэй цемент үйлдвэрлэх хүчин чадалтай.

1.4 Байгаль орчны баримтлах зарчим: Мөнхийн баян гал ХХК нь Монгол улсын байгаль орчны тухай хууль тогтоомж, журмыг дагаж мөрдөх төдийгүй Хятадын үндэсний тэргүүлэгч компани гэдэг утгаараа байгаль дэлхийгээ хайрлах сэтгэлээр хандаж, байгаль эхийнхээ эд, эс бүхнийг анхааран арчилж, хамгаалан ажиллахыг хэрэгжүүлж буй төсөл, үйлдвэртээ бүхий л үйл ажиллагааны туршид мөрдлөг болгон ажилладаг билээ. Мөн манай компани нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах тал дээр ихээхэн хэмжээний хөрөнгийг зарцуулан

ажилласаар ирсэн бөгөөд цаашид улам сайжруулах бодлогыг баримтлан ажиллаж байна. Үүний нэг илрэл нь манай төрийн болон орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудын тогтмол хийдэг шалгалт, үнэлгээ зэргээс гадна байгаль орчны чиглэлийн олон улсын өндөр шаардлага бүхий хөндлөнгийн байгууллагууд, компаниудын олон удаагийн шалгалт, судалгаагаар ирэх явдал юм.


1.5 Үйлдвэрлэлийн технологи: Үйлдвэрлэлийг дэвшилтэд технологи, байгаль орчинд ээлтэй, чанарын өндөр баталгаатай үйлдвэрлэх технологийг мөрдөж DCS хяналтын систем нэвтрүүлэн, сүүлийн үеийн тоос шүүх дэвшилтэд технологи ашиглаж, үйлдвэрийн энерги зарцуулалтыг хамгийн доод хэмжээнд хүргэхээр зориж байна.

Түүхий эдийн агуулах нь үйлдвэрийн хойд хэсэгт байрлах ба үүнд шохойн чулуу бутлах хэсэг, шохойн чулуу овоолох талбай, шохойн чулуу жигд болгож бэлтгэх агуулах, туслах материал болон нүүрс жигд болгож бэлтгэх агуулах, нүүрс бэлтгэх талбай зэрэг багтдаг. Гол үйлдвэрийн бүс нь үйлдвэрийн гол хэсэгт байрлах бөгөөд энэ хэсэгт түүхий эд материал хуваарилах станц, түүхий эд материал нунтаглах тасаг, түүхий эд материалын бэлдэцийн агуулах, чийгшүүлэх цамхаг, зуухны төгсгөл хэсгийн тоос сорох төхөөрөмж, шатаах зуухны гол хэсэг, шатаах зуухны толгой хэсэг, шатаах зуухны толгой хэсгийн тоос сорох төхөөрөмж, нүүрснийн нунтаг бэлтгэх төхөөрөмж, клинкер /чулуунцар /-н агуулах зэргийн байгууламжаас гадна цемент нунтаглах байгууламж, цементийн агуулах, цементийн задгай тээвэрлэлтийн зам, баглаа боодол болон бэлэн бүтээгдэхүүний агуулах нь үйлдвэрийн өмнөд хэсэгт байрлах ба харин ажилчдын орон сууц хороолол нь үйлдвэрийн хамгийн хойд хэсэгт байрлана.



Зураг 2. Үйлдвэрийн технологийн бүдүүвч

Цементийн үйлдвэрийн технологийн дарааллын ерөнхий схем



Зураг 3. Технологийн ерөнхий схем


1.6 Түүхий эд: Үйлдвэрийн үндсэн түүхий эд болох шохойн чулууг голчлон үйлдвэрээс 80 км орчим зайтай Төв аймгийн Баянцагаан сумын нутгаас шохойн чулууг тээвэрлэгч байгууллагад захиалсан захиалгын дагуу авч ашигладаг. Мөн бусад түүхий эд болох гөлтгөнө, шавар зэргийг түүхий эд худалдаж буй компаниудаас нийлүүлэн авч 32.5, 42.5 маркийн цемент, хэрэгцээт захиалгын дагуу 52.5 маркийн цемент үйлдвэрлэнэ. Мөн сүүлийн үеийн тоног төхөөрөмж бүхий лабораторийг ашиглалтад оруулж итгэмжлэгдсэн лаборатори болгон ажиллаж байна. 2-р ээлжийн өдөрт 2500 тонн чулуунцар шатаах хүчин чадалтай шугам нь 2016 оны 6-р сард ашиглалтад орж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж бүрэн ажиллаж байна. Чулуунцар шатаах хэсэг бүрэн хүчин чадлаар ажиллаж

байна. Манай цементийн иж бүрэн үйлдвэр Монгол улсын эдийн засгийн хөгжил болон барилгын салбарын хөгжилд эергээр нөлөөлж үнийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж ажиллаж байна. Манай үйлдвэрийн зорилго нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, шинэ арга техник технологиор тогтсон стандартын техникийн шаардлагад нийцсэн цемент үйлдвэрлэж, эх орны бүтээн байгуулалтыг цементээр бүрэн хангах зорилготой үйлдвэрлэл явагдаж байна.

Төслийн талбайн координат цэг

Хүснэгт 5. Координат цэг

№	Өргөрөг			Уртгаг		
1	47 ⁰	32'	6.9''	107 ⁰	18'	26.0''
2	47 ⁰	32'	4.81''	107 ⁰	18'	13.16''
3	47 ⁰	32'	11.5''	107 ⁰	18'	11.2''
4	47 ⁰	32'	7.1''	107 ⁰	17'	46.6''
5	47 ⁰	32'	22.6''	107 ⁰	17'	33.47''
6	47 ⁰	32'	45.88''	107 ⁰	17'	20.27''
7	47 ⁰	32'	51.2''	107 ⁰	17'	59.2''
8	47 ⁰	32'	47.56''	107 ⁰	18'	4.51''
9	47 ⁰	32'	36.99''	107 ⁰	18'	7.86''
10	47 ⁰	32'	34.31''	107 ⁰	18'	9.63''
11	47 ⁰	32'	27.86''	107 ⁰	18'	10.8''
12	47 ⁰	32'	21.2''	107 ⁰	18'	13.0''
13	47 ⁰	32'	12.6''	107 ⁰	18'	22.0''



Зураг 4. Төлөвлөлтийн тойм зураг

2. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Цемент үйлдвэрлэх үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, болон бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2022 онд боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгаж өгсөн байдаг.

Цемент,чулуунцар үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон

“Чулуунцар боловсруулж хуурай аргаар цемент үйлдвэрлэх” төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөл нь экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны төлөв байдлын чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх болон түүх соёлын дурсгалт зүйлс, археологи палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудлууд болон нөлөөллийн бусад хэсгүүдийг хамруулан шууд, шууд бус, богино болон урт хугацааны, эрчимшлийн хувьд хүчтэй, дунд болон бага гэх мэтчилэн ангилж магадлан жагсаах аргаар үнэлсэн.

Хүснэгт 6. Болзошгүй нөлөөллийн схем

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх усны нөөцийн өөрчлөлт	x				x		x			
Гадаргын усны нөөцийн өөрчлөлт		x			x		x			
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x			
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x			
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							
2.Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг	x				x		x			
Бэлчээрийн байдал	x				x	x				
Эрдэс түүхий эдийн нөөц	x									
Эрчим хүчний нөөц		x			x					x
3.Байгаль орчны чанарын өөрчлөлт										

Газар доорхи усны чанарын өөрчлөлт	x				x	x				x
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x	x				
Агаарын бохирдол		x				x				x
Хөрсний бохирдол	x					x				

Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх										
---	--	--	--	--	--	--	--	--	--	--

Дуу чимээ, шуугианы нөлөө										x
---------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	---

4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор

Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх					x		x		x	
--------------------------------------	--	--	--	--	---	--	---	--	---	--

Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх					x		x		x	
------------------------------------	--	--	--	--	---	--	---	--	---	--

Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
-------------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	--

Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										x
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

5. Эдийн засаг, нийгмийн асуудал

Орон нутгийн орлого нэмэгдэх					x				x	
------------------------------	--	--	--	--	---	--	--	--	---	--

Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох					x				x	
------------------------------------	--	--	--	--	---	--	--	--	---	--

Ажлын байр нэмэгдэх					x				x	
---------------------	--	--	--	--	---	--	--	--	---	--

Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх										
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх										x
--------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--	---

6. Бусад нөлөөлөл

Ажлын нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх							x			x
--	--	--	--	--	--	--	---	--	--	---

Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих, хөрс бохирдох							x			x
--	--	--	--	--	--	--	---	--	--	---

Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга										x
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

Дүн	14	10			15	11	1	2	10	10
-----	----	----	--	--	----	----	---	---	----	----

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 7. Агаарын чанар



№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
<i>3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</i>					
1	Дуу чимээ, тоосжилттой ажлын байранд ажиллах ажиллагсдыг маск, иж бүрэн хувцас, чихний бөглөө, нүдний шил зэрэг хамгаалах хувцас хэрэгслээр хангах	Үйлдвэрийн нийт ажилчдад	Нийт ажилтын эрүүл ахуйн үүднээс хамгаалах хэрэгслээр тогтмол хангаж ажиллав.	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардал	Жилийн турш
2	Бутлах, шигших, нунтаглах, холих, ачих буулгах бүх цехүүдийн агааржуулах хоолой бүрт тоос баригч уутан филтрүүдийн ашиглалт арчилгааг хийх	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн шат дамжлагуудаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор бүх хэсгүүдийн уутан филтрүүдийг тухай бүрт солиж байршуулдаг.	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардал	Тухай бүрт
3	Агаарын чанарын хяналт шинжилгээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх,	Үйлдвэрийн хэмжээнд	Мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлэв.	260,000	Жилд

3.1.1 Дуу чимээ, тоосжилттой ажлын байранд ажиллах ажиллагсдыг маск, иж бүрэн хувцас, чихний бөглөө, нүдний шил зэрэг хамгаалах хувцас хэрэгслээр ХАБЭА-н хуулийн журмын дагуу тогтмол олгож ажилладаг болно.



Зураг 5. Тоосжилттой орчны хувийн хамгаалах хэрэгсэл

3.1.2 Тоожилтыг бууруулах, агаар орчинд дэгдэхээс сэргийлж үйлдвэрийн тоос ялгаруулах тоног төхөөрөмжийн уутат шүүлтүүрүүдийн филтерийг тогтмол солиж арга хэмжээ авч ажиллаж байв.



Зураг 6. Уутан шүүлтүүр солиж буй байдал

3.1.3 Агаарын болон дуу чимээний шинжилгээг “БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ”-оор Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд.Ажлын байрын орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5000:2000, зэрэг тус тус стандартыг үндэс болгон Нийт 5 цэг бүхий газар хийж гүйцэтгүүлэв.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үүсдварь 2-4, Чамгисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: tobi@bayngal.com

СОРИЛТЫН ДҮН

Дугаар шалтгам	2024/А-180
Сорилт нэр	"Мөнхийн Баян Гал" ХХК
Сорилтын зорилго	1. Дотоодын агаарын ажил
Сорилтын хугацаа	5 асар, 8 дугь чамд
Сорилтын өдөр	2024.08.08
Сорилтын газар	1 Төв аймаг, Сэлэнгэний тус 1-р баг 7-р өрөөл
Шалтгамтай өргөн стандарт	MNS 17-0-06:2021, MNS 17-2-2-11:2021
Шалтгамтай өргөн стандарт	MNS 5002:2000, САЗ А07-2018
Хуудасны тоо	2/2024.08.07
Хуудасны тоо	1/1


№	Сорилт нэр	Сорилт нэр	Сорилт нэр	Хүчинлэг хэд	Ажлын дугаар	1 мкг/м³-д	Дуу чимэг
1	Түүхийн мандал тархалт	MNS 4585	17.00	0.008	0.049	0.072	25.4
2	Сорилтын мандал тархалт	MNS 4585	18.25	0.008	0.053	0.073	31
3	Хүлцэх гадна тархалт	MNS 4585	13.00	0.008	0.038	0.113	85
4	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын ажлаар)	MNS 4585	14.00	0.011	0.058	0.118	91
5	Хүлцэх агууламж	MNS 4585	13.00	0.011	0.052	0.287	78
6	Сорилтын дүнг	MNS 4585	14.00	0.011	0.052	0.287	78
7	Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015	MNS 4990	2	2	2	2	2
8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5000:2000	MNS 5000	2	2	2	2	2

Шалтгамтай гүйцэтгэсэн инженер: *[Signature]* Э. Оюунтуяа
Хяналт байгууллагын дарга: *[Signature]* Б. Барзаспилс
Байгаль орчны шалтгамтай өргөн стандартын дарга: *[Signature]*

Хууль ёсоор заргалзсан сорилтын дүнгийг үндэс болгон сорилтын дүнг нь ажлын шалтгамтай өргөн стандартын хүчинтэр.

Зураг 7. Агаарын шинжилгээ хийж буй байдал

Зураг 8. Цементийн үйлдвэр орчим тодорхойлсо нхүхэрлэг хий буюу SO₂,NO₂-ын агууламж



Хүснэгт 8. Усны чанар


№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
3.2 Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Бохир ус цэвэрлэгээний байгууламжийн үйл ажиллагааг хэвийн горимд үе шаттай шилжүүлэх,	Үйлдвэрийн суурьшлын хэсэгт	Амралтын байр гал тогооны хэсгийн цэвэрлэх байгууламжийг эхний ээлжинд хэвийн ажиллагаанд оруулав. Ажлын явц 85%	500.000.0	Жилийн турш
2	Гүний болон хаягдал усны чанарын шинжилгээг улиралд 2-оос доошгүй удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйлдвэрийн хэмжээнд	Улирал бүр эрх бүхий мэргэжлийн байгууллагаар цэвэр ус болон, бохир усны шинжилгээг тогмол хийлгэн ажилладаг болно.	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардал	Улирал бүрт
3	Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар мониторингын цооног гаргах	Үйлдвэрийн хэмжээнд	Мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлэв.	42.000.000	Жилд
4	Усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх	Бүх худгуудын	Тоолуурын заалтаар жилийн туршид ашигласан усны төлбөрийн төлсөн.	11.259.285	Жилийн турш

3.2.1 Ахуйн хэсгийн цэвэрлэх байгууламжийг засаж янзлан хэвийн ажиллагаанд оруулахаар ажиллаж байна. Ажлын явц 85 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд уг хэсгийн усыг цэвэрлэж эхэлсэн. Мөн үе шаттай үйлдвэрлэлийн хэсгийн цэвэрлэх байгууламжийг засаж хэвийн ажиллагаанд оруулахаар төлөвлөж байгаа.



Зураг 9. Цэвэрлэх байгууламж засаж буй байдал

3.2.2 Үйлдвэрийн хяналт шинжилгээний хүрээнд улирал бүр хөрс болон цэвэр усны, мөн бохир усны шинжилгээ, мониторингийг тогтмол орон нутгийн шинжилгээний лаборатори болон, байгаль орчны газрын хэмжилзүйн лабораторид шинжлүүлж хэвшсэн болно.



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Улаанбаатар 2-4, Чингэлэйрин аргын чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: mns@bayangal.mn

СОРИЛТЫН ДҮН

Дугаар о/№ : 2024 / Б-135-136
 Сорьц чулуутас газрын мөө, хөвг, утас : “Мөнхийн Баян Гал” ХХК
 Сорьц авсан хувий тус, аргын туслах : Д.Даваржавын: 0006070
 Сорьц арга төслөрөл : 2, Өснөр үс
 Сорьц авсан өгөөс : 2024.07.18
 Сорьц арга төслөрөл : Үндэсний бохир усны сорьц
 Шинжилгээний аргын төлөвлөгөө : MNS ISO 15023:2001, MNS 8838:2020
 MNS 6833:2020, MNS ISO 9115-1:2016
 MNS 1097:2023, MNS ISO 6779:2019
 MNS 8834:2020, MNS ISO 8878:2001

Шинжилгээний өгөөс : 2024.07.19 2024.07.25
 Хураанах тус : 1/1
 Тр-ын : 2

Сорьц авсан цэг	pH	ЖОС мг/л	ХОХ-АМ мг/л	СХХс мг/л	МН-Н мг/л	NO ₃ -N мг/л	NO ₂ -N мг/л	N-ам мг/л	Р-ын мг/л
Төв аймаг Сэлэнгэ-Ом, Т-у баг, Сурвалжны эрэг	7.24	2.0	9.8	9.2	5.24	0.003	1.76	7.09	0.488
Төв аймгийн эрэг	9.77	7.8	7.1	4.2	0.31	0.006	0.20	0.51	0.029

MNS 6861:2016 6.0-9.0 400 800 400 16 - - 30 5

Төвлөр: ISO 9001:2015 төлөр, ХХК-ын Аймаг, Харилцагч Урсгалын Төвлөрөөс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, МОН-ын Аймаг, Харилцагч Урсгалын Төвлөрөөс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжлэгч: А.Цолмонбаяр
 Шалгаасан шинжлэгч: В.Алурян
 Хянаж багалгааруулсан алхам шинжлэгч: Б.Алтантуяа

Хуульчлал хэрэгсэлгүй хэргийг хянаж, Сорьцны дүн нь зөвхөн шинжилгээний сорьцны үр дүнд байна.

МОНГОЛ 11:10 AM **GAZEL LABS**

МНЭ Accreditation center
711-0028
MNS ISO 9001:2015, ISO 17025

Хүргэлсэн Агууламд Байгууллага
Урьдчилсан Төлөвлөгөөний
Төвлөрөөс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2024 оны 05 сар 08 өдөр

**ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТЭСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН
ЛАБОРАТОРИ**
Төв аймаг: Зүүнмод сум, Номд 1-р багц
Утас: 70223619, Факс: 70223813

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS**

Бүртгэлийн дугаар /Registration number/: 24-09
 Шинжилгээний үйлчилгээний газрын нэр: Сэлэнгэ сум, Мөнхийн Баян Гал ХХК
 The name of customer's request for analysis:
 Дугаар лабораторийн нэр /Name of the sub laboratory/: Эрүүл ахуйн нийгэм судаллын хэлтэсийн лаборатори

Дэвжлийн дугаар /Sample number	Дэвжлийн нэр /Name of sample	Цэвэрлэлийн дугаар /Filter number	Тусгай аргаар үзэх /Special method	Бүтээгдэхүүний хэмжээний хувиар /Volume of sample	Дэвжлийн төв хэмжээ /Reference value
306	Улаанбаатар хотын урванд ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл
307	Сурвалжны эрэгний урванд ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл
308	Улаанбаатар хотын бохир ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл
309	Сурвалжны эрэгний бохир ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл
310	Улаанбаатар хотын бохир ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл
311	Сурвалжны эрэгний бохир ус		Монгол Улс	Тодорхойгүй	500.0 мл

Хүргэлсэн өгөөс /Date of issue	Шинжилгээ дууссан өгөөс /Date of completion	Хэвлэсэн өгөөс /Date of printing
2024 оны 04 сар 30 өдөр	2024 оны 05 сар 08 өдөр	2024 оны 05 сар 08 өдөр

Дэвжлийн дугаар /Sample number	Шинжилгээний аргын стандарт /Method standard	Шинжилгээний нэр, хэмжээний нэгж /Name and unit of measurement	Шинжилгээний үр дүн /Result	Шинжилгээний дүн /Reference value
306	MNS ISO 6222:1998	БЕЕТ	1 мл-д 100-аас 9999	1-ээс 1000
	MNS ISO 11870:2017	Гадаргын булчирхайн нэгж	100 мл-д 100-аас 9999	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун газартай гадаргын булчирхайн нэгж /литр	1 мл-д 100-аас 9999	Илрээгүй
	MNS ISO 6222:1998	БЕЕТ	1 мл-д 100-аас 9999	10
307	MNS ISO 11870:2017	Гадаргын булчирхайн нэгж	100 мл-д 100-аас 9999	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун газартай гадаргын булчирхайн нэгж /литр	100 мл-д 100-аас 9999	Илрээгүй

Дүн: mns@gazellabs.mn | 70223619 | 70223813

Зураг 10. Усны, хөрсний шинжилгээний зураг

3.2.3 Өрөмдлөгийн ажил мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэв.

А. Цооногийн гүн 130.0 м, Цооногийн солбицол: Уртраг 107° 17' 28.32300"
Өргөрөг 47° 33' 44.77040"

Өрөмдлөгийн арга: хийн цохилтот өрөмдлөгийн арга

Өрөмдлөгийн тоног төхөөрөмж: POWER-4000

Өрөмдлөгийн диаметр /мм/ ба гүн/м / 152/0.0-130.0/

Б. Цооногийн хийц, зохиомж:

Суултын яндан, шуур, тунгаагчийн диаметр /мм/ ба гүн /м/ ф159/0,0-24.0/, ф100/0,0-130.0/

Шүүрийн яндангийн диаметр /мм/ ба гүн /м/ -ф100/70-120.0/

Тунгаагчийн диаметр /мм/ ба гүн /м/ / ф100/120-130.01

В. Шавхалтын ажил:

Шавхалтын арга: эрлифт, насос Шавхалтын төхөөрөмж: INGERSOLL-900

Шавхалт үргэлжилсэн нийт хугацаа 24 цаг

Г. Гидрогеологийн үзүүлэлтүүд:

Ундарга 6,5 л/сек

Уст үеийн сэргээгдэх хугацаа

Тогтсон түвшин -0,6 м

Хувийн ундарга л/сек/м

Түвшин бууралт 38 м

Уст үеийн байршил /м 3-7, 16-23, 48-54, 70-75, 90-96

Д. Бусад үзүүлэлтүүд:

Хайрганы диаметр 5-10мм

Тампоначийн терел:

Хайрганы байршил 60,0-120,0м

Тампонач хийсэн гүн М

Шүүрийн төрөл: цуулбар

Шавхалт хийсний дараа усны түвшин, чанарыг хэмжигч логгер, агаарын даралт хэмжигч барологгер хэмжигч тоноглон суурилуулахтай холбоотой цооногийн битүүмжлэлийг найдвартай байдлыг хангах амсрын таг хийж байршуулав.



Зураг.11 Хяналтын цооног ухах газарт тоног төхөөрөмжөө байрлуулав.



Зураг 11. 130м цооногийн ажлыг бүрэн дуусгав.

3.2.4 Усны ашигласны төлбөрийг цаг тухайд нь тоолуурын заалтаар төлж тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.



“Мөнхийн баян гал” ХХК-ны 2024 оны ус ашиглалтын тоон мэдээлэл, худгын заалтын нэгтгэсэн акт

2024.04.17— 2024.11.07

№	Бичлэг хийсэн огноо	4-р хуви Үйлдвэрийн хэрэглээ			5-р хуви Үйлдвэрийн хэрэглээ			6-р хуви Ахуйн хэрэглээний			7-р хуви Ахуйн хэрэглээний			Нийт		Нийт м3	Нийт төлбөр /Монгол дүнгээр /
		Эхний залт	Эцсийн залт	Зөрүү /м3 /	Эхний залт	Эцсийн залт	Зөрүү /м3 /	Эхний залт	Эцсийн залт	Зөрүү /м3 /	Эхний залт	Эцсийн залт	Зөрүү /м3 /	Ахуйн хэрэглээ	Үйлдвэрийн хэрэглээ		
1	2024.04.17	Ашиглаагүй			Ашиглаагүй			19508	26458	6950	10641	10746	105	7055	0	7055	1,305.175
2	2024.07.30	24451	36272	11821	6868	6868	26458	36337	9879	10746	12639	1893	11772	18689	30461	5,635.285	
3	2024.09.20	36272	41158	4886	6868	9346	2478	36337	38262+2	4812	12639	12684	45	4857	7364	12221	2,260.885
4	2024.11.07	41158	45627	4469	9346	11644	2298	2887	7210	4323	12684	12718	34	4357	6767	11124	2,057.940
5	Нийт дүн			21176			11644						2077	28041	32820	60861	11,259.285

Хянасан:

Төв аймгийн БОАЖГ-ын усны мэргэжилтэн

Заалт авсан

“Мөнхийн баян гал” ХХК-ны БО-ны мэргэжилтэн

Нэгтгэсэн :

“Мөнхийн баян гал” ХХК-ны БО-ны хэлтсийн дарга

 /Ж.Оюуннاران /
 /Д.Даваарэгзэн /
 /Жан Гуан Ли /

Хүснэгт 9. Ургамлын чанар

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
3.3 Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах	Үйлдвэрийн суурьшлын хэсэгт	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгаж өгөв.	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардал	Жилийн турш
2	Үйлдвэрийн болон орчны талбай дахь амьтны аймаг нөлөөлөлд өртөх	Үйлдвэрийн хэмжээнд	Ажиглалт судалгааг үйлдвэрийн хэмжээнд хийж хэрэгжүүлэв.	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардал	Улирал бүрт

3.3.1 Хөрсний элэгдэл эвдрэлийн улмаас хөрсний ус чийг багасах, бүтэц эвдрэх, ургамал ургах тааламжтай нөхцөл алдагдах нөлөөтэй тул ургамлын нөмрөг өөрчлөгдөж устахад хүрдэг. Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

➢ Ургамлын бүрхэвчийг сөрөг нөлөөллөөс хамгаалах нэг гол арга нь элдэв химийн найрлага бүхий тоосонцрыг орчинд тархаахгүй байлгахад оршино. Мөн авто замын сүлжээ, барилга байгууламж бүтээн байгуулалтын төлөвлөгөөг оновчтой тодорхойлох.,

➢ Хөрсжүүлэлт, ургамалжуулалтын ажлыг холбогдох технологи, стандартын дагуу хамгийн зохистой хугацаа норм хэмжээ, агро-арчилгааны дагуу гүйцэтгэхэд мэргэжлийн

байгууллагатай хамтран тухайн орчинд ногоон байгууламж байгуулах

- Мод, бутлаг ургамлаар орчныг тохижуулах
- Хүн, техник, хог хаягдлын нөлөөгөөр байгалийн ургамал устгах, талхлагдах, хөл газрын ургамал давамгайлж зүйлийн бүрдэл өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх зэргээр арга хэмжээ авч ажиллав. Үйлдвэрийн ургамлын нөмрөг болон ногоон байгууламжийг сэргээхийн тулд 3000 гаруй мод бут сөөгийг тариж ургуулав. /Ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлтэд тусгав. /

3.3.2 Төслийн талбай орчимд зэрлэг ан амьтан байхгүй боловч ойр орчим хөхтөн амьтан, Шувуу, туулай зэргийн ан амьтдын сэргийлэхийн тулд үйлдвэрийн барилга байгууламж, төслийн талбай нүх шуудуу болон, хиймэл нууранд ан амьтан орохоос хамгаалж хашаа хороо бэхжүүлж ажиллав.

- Төслийн талбай орчинд, хог хаягдал түр хадгалах цэгт элдэв мэрэгчид, шувуу, шавьж элбэгших явдлыг хянах.ил задгай ахуйн болон үйлдвэрийн хаягдал хаяхгүй байх нөхцөлийг ханган ажиллаж байна.

Хүснэгт 10. Улирдлага зохион байгуулалт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
<i>3.4 Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ</i>					
1	Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Нийт ажилчид	Эрүүл мэндийн хугацаат үзлэг оношилгоог орон нутгийн эмнэлэгээр хийлгэв.	Үйлдвэрийн урсгал зардал тусгав.	Жилийн турш
2	Ажлын байранд онцгой байдлын болон гар унтраах иж бүрэн багаж хэрэгслийг авч, байрлуулах.	Үйлдвэрийн бүх объект	Үйлдвэрийн бүх объект, хэсгүүд дээр галын хорны иж бүрдийг байрлуулж шинэчлэн тохижуулав.	Үйлдвэрийн үйл ажиллагааны зардал	Жилийн турш
3	Ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	Үйлдвэрийн хэмжээнд	Жил бүр тогтмол хэрэгжүүлдэг ажил	Үйлдвэрийн урсгал зардал тусгав.	Жилд
4	Хяналт шинжилгээний үр дүнгүүдийг орон нутгийн захиргаа, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэдний саналыг авах	Орон нутгийн засаг захиргаа	БО-ны тайланг батлагдмагц хяналтын хуудсаар санал авна.	Үйлдвэрийн урсгал зардал тусгав.	4-р улиралд

3.4.1 Үйлдвэрийн нийт ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг онишлгоонд оруулав.



Зураг 12. Ажлын байранд үзлэгт хамрагдаж буй байдал.

3.4.2 Ажлын байранд онцгой байдлын гар унтраах иж бүрэн багаж хэрэгслийг авч, байрлуулах.
Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,



Зураг 13. Галын сараануудыг шинэчилсэн байдал.

Гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэгийг өдөр тутам зохион байгуулан, хяналт тавьж ажилладаг. Үйлдвэрийн хэмжээнд гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл 13 ширхэг объектод байрладаг, тайлант онд бүгдийг шинэчлэн сайжруулсан. галын гидрантуудын ажиллагааг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангасан. Нийт ажилтнуудад онцгой байдлын авран туслах үйл ажиллагаа ба танхимын анхны тусламжийн, иж бүрэн сургалтыг орон нутгийн онцгой байдлын аврагч нартай хамтран орж ажиллуулах зарчим болон яаралтай үеийн гал унтраах үйл ажиллагааг зааж сургав.



Зураг 14. Сургалт зохион байгуулж байгаа байдал.

3.4.3 Ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр жил бүр бүрэн хангаж ажиллаж хэвшсэн бөгөөд тоосжилтоос хамгаалахын тулд цогц арга хэмжээний дагуу тоног төхөөрөмжийн эх үүсвэр дээр уутат шүүлтүүр, ажилчдын шүүлтүүртэй маскаар бүрэн хангаж, цаг тухайд нь маскийн филтерийг солин ажиллаж байв. /Агаар орчны сөрөг нөлөөллийн хэсэгт бүрэн тусгаж, зургаар харуулав. /

3.4.4 Хяналт шинжилгээний үр дүнгүүдийг орон нутгийн захиргаа, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэдний саналыг авах төлөвлөгөөний хүрээнд;
Орон нутгийн багийн иргэдэд тайлант оны байгаль орчны хийж хэрэгжүүлсэн ажлыг танилцуулан тулгамдаж буй асуудал хэлэлцэн ярилцав.



Зураг 15. Сургалт зохион байгуулж байгаа байдал.

4. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хүснэгт 11. Ногоон байгууламж

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нэгжийн өртөг /сая. төг/	Нийт зардал /сая. төг/	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрийн газрын байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор мод тарьж ногоон байгууламжийг өргөтгөн байгуулах	Үйлдвэрийн талбайд, Гол зам дагуу	2024 оны хувьд мөн нийт 3000 гаруй модыг тарьж ургуулсан бөгөөд, өмнө жилүүдэд тарьж ургуулсан мод бут сөөгийг арчлан усалж ажиллав.	1-2 га-д тарих модны тоо 3000 ш суулгац нийт 15 га * 3000ш =45000 ш суулгац нэг суулгацын дундаж үнэ 6000 төгрөг	84.0 сая төг	4, 10 сард тариалалт хийв.	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл.
НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН:			2024 оны тариалалтын зардал: 84 сая.төг			

Цемент шохойн үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах, орчны тохижилт бий болгох зорилгоор ногоон байгууламжийг жил бүр нэмэгдүүлж 2023-2024 онуудад өссөн дүнгээр нийт 4 га талбайд 6000 гаруй мод, сөөгийг арчлан ургуулж байна.

2024 онд үйлдвэрийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлын хүрээнд хавар 4-р сараас талбайн хөрс боловсруулалт, нүх ухах ажил эхэлж 3 байршилд 2 төрөл зүйлийн 3000 ш мод сөөг тарьж ургуулсан байна.

Компанийн үйлдвэрийн талбайд тухайн бүс нутагт дасан зохицсон, амьдрах чадвар өндөртэй мод сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлын суулгацыг бэлтгэх, биологийн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулах зорилгоор 8 га талбайд 2021 оноос хойш хийж эхлээд байгаа билээ.



Зураг 16. Нийт талбайн ногоон байгууламжийн төлөвлөлт.



Зураг 17. Хаврын тарилтын нүх ухаж буй байдал



Зураг 18. Мод тарилтын дараа болон, тарилтын дараах усалгаа арчилгаа хийж байгаа нь

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

